



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 6 сарын 23 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

XXIV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXIV хурал 2020 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордны Шадар сайдын өрөөнд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. БНХАУ-ын Бээжин хотын нэр бүхий хүнсний захуудад тархаад буй коронавируст халдвар /КОВИД-19/-ын нөхцөл байдлын талаар;

*Гадаад харилцааны сайд
Д.Цогтбаатар*

2. Эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг 7 дугаар сард татан авах захиалгат нислэгийн талаар;

*Гадаад харилцааны яамны
Консулын газрын захирал
Л.Мөнхтүшиг*

3. Дипломатуудыг тусгаарлах горимын тухай;

*Гадаад харилцааны сайд
Д.Цогтбаатар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Ч.Улаан,
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,
Гаалийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт нарт:

1.1. Загас ба далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг БНХАУ-аас 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс 7 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд улсын хилээр нэвтрүүлэхийг түр хязгаарлах;

1.2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалт шинээр бүртгэгдсэн БНХАУ-ын Бээжин хотын зарим хүнсний захуудад худалдаалагдаж буй хүнсний ногоо, жимс жимсгэнэ, далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлж, Монгол Улсад импортлогдож буй хүнсний ногоо, жимс жимсгэнэд урьдчилсан шинжилгээг БНХАУ-д хийсний дараа хилээр нэвтрүүлэх боломжийн талаар судлах;

Хоёр. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Ч.Улаан,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

2.1. Амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнд /шаардлагатай үед/ тандалт шинжилгээ хийх "BSL" III зэргийн вирусны лабораторийн бэлэн байдлыг хангаж, шинжилгээнд шаардлагатай оношлуур хэрэглэгдэхүүний нөөцийг бүрдүүлэх;

2.2. Монгол Улсад импортоор ирж буй амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлоос сорьц авч баталгаат лабораторийн шинжилгээнд хамрагдсан эсэхийг шалгаж, аюулгүй байдлыг хангах;

Гурав. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайханд:

3.1. Бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбогдсон хууль, дүрэм, журмын хүрээнд ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг чанд сахиж зарим олон нийтийн үзвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээг эхлүүлэх талаар саналаа судлан Улсын онцгой комисст танилцуулах;

Дөрөв. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав нарт:

4.1. Олон улсын ачаа тээврийн хамгаалалт, хяналтад үүрэг гүйцэтгэж буй Цагдаагийн байгууллагын автомашин замын нөхцлөөс хамааран эвдрэл, гэмтэл үүсч, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангахад хүндрэл учирч байгаа тул тээвэрлэлтийн хэвийн нөхцлийг хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газарт Улсын нөөцөөс тодорхой тооны автомашин олгож, дэмжлэг үзүүлэх, нөхөн бүрдүүлэх арга хэмжээ авах;


Тав. Батлан хамгаалахын сайд,
Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболд,
Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Д.Ганзориг нарт:

5.1. ОХУ-д суралцаж буй эх орондоо буцах хүсэлтэй цэргийн сургуулийн сонсогчид, Аугаа их эх орны дайны ялалтын баярын ёслолын жагсаалд оролцоод эргэн ирэх цэргийн алба хаагчдыг тээвэрлэх, тусгаарлахтай холбогдох ажиллагааг хариуцаж, холбогдох зардлыг гаргах;

Зургаа. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

6.1. Гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын ажилтнуудыг тухайн ДТГ-ын байранд тусгаарлах нарийвчилсан горимыг тогтоон, гадаад улсын ЭСЯ, ДТГ-тай хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах;

ДАРГА,
ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Д.САНЖАА